



# Удирдагчид зориулсан удирдамж

---

**БИЕ ДААСАН БАЙДАЛ**

## ӨМНӨХ ҮГ

Бидний дунд асар их хэрэгцээ байна. Олон гишүүн бие даах чадваргүй ба “өөрийнхөө болон гэр бүлийнхээ сүнслэг ба материаллаг хэрэгцээг хангах” чадвараар дутмаг байдаг.<sup>1</sup> Хүмүүсийг бие даах чадвартай болгох нь авралын ажил юм. Ерөнхийлөгч Томас С.Монсон: “Бие даах чадвар нь . . . бидний сүнслэг болон материаллаг сайн сайханд нэн чухал. . . . Бие дааж амьдрах чадвартай, бусдаас хамааралгүй байцгаая. Авралыг өөр ямар ч зарчмаар олж авах боломжгүй”<sup>2</sup> хэмээн заажээ.

Илүү бие даасан болоход нь тусалбал зохих хүмүүст мацгийн өргөлийн тусламж авдаг хүмүүс, эргэж ирсэн номлогчид, дөнгөж хөрвөгдсөн болон идэвх султай гишүүд, мөн илүү сайн ажилд орох хэрэгтэй байгаа тухайн орон нутгийн санваарын удирдагчид орно. Өнөө үед Их Эзэн гишүүдэд бие даах чадвартай болох явцад нь туслахын тулд энэхүү удирдамж дээр дурдагдсан шинэ арга хэрэгсэл, эх сурвалж, арга барилыг Өөрийн Сүмээр дамжуулан хангаж байна.<sup>3</sup>

Та санваарын удирдагчийн хувьд Их Эзэний “тэдгээрийн түлхүүрүүдийг, . . . тохинууллын хийгээд миний гэгээнтнүүдийг төгөлдөржүүлэх ажлын тулд би та нарт өглөө” (С ба Г 124:143), мөн “эдгээр түлхүүрүүд өгөгдсөн түүнд хүмүүний [үрсийн], . . . авралтай холбогдсон баримтуудын мэдлэгийг олж авах нь хэцүү биш болой” (С ба Г 128:11) хэмээн хандан хэлсэн хүмүүсийн нэг болно. “Автобусны жолоочийн зүйрлэл”-ийг унш. Энэ чухал ажлыг урагшлуулахад өөрийн гүйцэтгэх үүргийг тунгаан бод.

Удирдагчид зориулсан энэ удирдамж нь түлхүүрүүдээ ашиглан, эдгээр шинэ арга хэрэгслийг хэрэгжүүлж, бие даах чадвартай болохын тулд өөрөө өөрсдөдөө туслахад нь гишүүдэд туслах таны ажилд дэмжлэг тусалцаа үзүүлэх зорилгоор бэлтгэгдсэн юм. Таныг үүнийг хийх үед Ариун Сүнс таныг удирдаж, Их Эзэн ядуус болон гачигдагсдыг өргөх, мөн Түүний авралын ажлыг яаравчлуулах үйл хэрэгт өөрийн мутар дахь зэмсэг болгоно.

1. *Гарын авлага 2: Сүмийг удирдах нь* (2010), 6.1.1.

2. Томас С.Монсон, (Марион Ж.Ромнигоос эш татав), “Guiding Principles of Personal and Family Welfare,” *Ensign*, 1986 оны 9-р сар, 3.

3. Дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл [sfs.lds.org](http://sfs.lds.org)-ийг үзнэ үү.

---

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмээс хэвлэн гаргав  
Юта муж, Солт Лэйк хот

© 2015 by Intellectual Reserve, Inc.

Бүх эрх хамгаалагдсан.

Англи эхийн зөвшөөрөл: 8/13

Орчуулгын зөвшөөрөл: 8/13

*Leader Guide*-ийн орчуулга

Mongolian

12373 363

## Автобусны жолоочийн зүйрлэл

“Бие даах чадвар хөгжүүлэх ажил нь үнэмлэхтэй жолооч шаарддаг автобустай адил юм.

“Бие даах чадвар хөгжүүлэх төвийн ажилтнууд автобусыг бүтээсэн. Энэ нь бие даах чадвар хөгжүүлэх төвөөр дамжин хүргэгдэх ба гадасны бие даах чадвар хөгжүүлэх хороо засвар үйлчилгээг нь хийнэ. Гадасны бие даах чадварын мэргэжилтнүүд болон бүлгийн зохицуулагчид гишүүдэд автобусанд суухад нь тусална (гэхдээ гишүүд өөрсдөө ирж автобусанд суух ёстой). Гадасны ерөнхийлөгч ба бишопууд нь автобусны жолооч юм.

“Гишүүдийг бие даах чадвартай болоход нь туслахын тулд бүх хүн оногдсон үүргээ биелүүлэх ёстой. Гэхдээ гадасны ерөнхийлөгч, бишопууд түлхүүрээ эргүүлэн хөдөлгүүрийг асааж, автобусыг жолоодохгүй л бол хэн ч, хаашаа ч явж чадахгүй.”

**РОНАЛД АБАН, Филиппиний Таклобаны бие даах чадвар хөгжүүлэх төвийн менежер**

## САНВААРЫН УДИРДАГЧИЙН ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

### Гадасны ерөнхийлөгчийн зөвлөл (эсвэл дүүргийн ерөнхийлөгчийн зөвлөл)

1. Бие даасан байдлын сургаал, зарчмуудыг судал мөн заа (арын хавтсыг үзнэ үү). Бишопт болон гадасны бие даах чадвар хөгжүүлэх хорооны гишүүдэд бие даах чадвар хөгжүүлэх үүрэг хариуцлагынх нь талаар заавар өг.
2. Гадасны бие даах чадвар хөгжүүлэх зорилгыг тодорхойл.
3. Гадасны бие даах чадвар хөгжүүлэх төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэн, хяналт тавих гадасны бие даах чадварыг хөгжүүлэх хороог байгуул.
4. Юуны өмнө эргэж ирсэн номлогчдыг болон шинэ хөрвөгчдийг (шаардлагатай бол) бие даах чадвар хөгжүүлэх төвийн үйл ажиллагаанд оролцоход урь.
5. Гадасны зөвлөлийн хэлэлцэх асуудалд бие даах чадвар хөгжүүлэх асуудлыг оруул.
6. Гадасны бие даах чадвар хөгжүүлэх мэргэжилтэнг дууд.
7. Шаардлагатай үед Сүмийн үйлчлэлийн номлогчдыг дууд.
8. Гадасны бие даах чадвар хөгжүүлэх үйл ажиллагааны явцын тухай болон ТБС-ийн зээлийн тайлантай танилцаад, тэдгээрт үндэслэн үйлд.
9. Шаардлагатай үед гэр бүлийн түүхийн төвийг бие даах чадвар хөгжүүлэх төвийн зориулалтаар хамтран ашиглах тухай удирдамж гарга.

### Гадасны бие даах чадвар хөгжүүлэх хороо

Гадасны бие даах чадвар хөгжүүлэх хорооны бүрэлдэхүүнд дараах хүмүүс орно. Үүнд: гадасны ерөнхийлөгчийн зөвлөл (дарга), бие даах чадвар хөгжүүлэх хөтөлбөрийг хариуцахаар томилогдсон Дээд зөвлөлийн гишүүн, гадасны Халамжийн нийгэмлэгийн ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн, бишопын халамжийн асуудал хариуцсан зөвлөлийн дарга болон гадасны бие даах чадвар хөгжүүлэх мэргэжилтэн.

Тус хорооны бүрэлдэхүүнд Залуу эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн ерөнхийлөгчийн зөвлөлүүд, гадасны өөр бусад мэргэжилтэн, бүрэн цагийн ахмад номлогчид болон Сүмийн үйлчлэлийн номлогчид орж болно.

1. “Бие даах чадвартай болохын төлөө хөдөлмөрлөх нь” видео бичлэгийг ([srs.lds.org/videos-00c](https://srs.lds.org/videos-00c)) үзнэ үү.
2. Гадасны бие даах чадвар хөгжүүлэх төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэн, хяналт тавь.
3. *Миний бие даах чадвартай болох арга зам* нэртэй онцгой цугларалтыг тогтмол зохион байгуул (4-р хуудсыг үзнэ үү).
4. Гадасны бие даах чадвар хөгжүүлэх төвийг зохион байгуулан, ажилтнуудыг бүрдүүл. Төвийн үйл ажиллагааг удирдаж, бие даах чадвар хөгжүүлэх бүлгүүдийг зохион байгуулах Сүмийн үйлчлэлийн номлогч хосыг эсвэл бие даах чадвар хөгжүүлэх мэргэжилтэнг томил (2-р хуудсыг үзнэ үү).
5. Тойргийн зөвлөлд бие даах чадвар хөгжүүлэх үүрэг хариуцлагынх нь талаар заа.
6. Бие даах чадвар хөгжүүлэх төвийн ажилтнуудын боловсруулан гаргасан эх сурвалж ба үзүүлж буй үйлчилгээг ашигла.
7. Эргэж ирсэн номлогчдыг болон шинэ хөрвөгчдийг (шаардлагатай бол) *Миний бие даах чадвартай болох арга зам* онцгой цугларалтад оролцож, бие даах чадвар хөгжүүлэх бүлгүүдэд нэгдэхэд урь.



“Бие дааж амьдрах чадвар бол бидний хөдөлмөрийн үр дүн бөгөөд бусад халамжийн ажлын үндэс суурь юм. . . . ‘Хэрэгтэй зүйлийнхээ төлөө хөдөлмөрлөцгөө. Бие дааж амьдрах чадвартай, бусдаас хамааралгүй байцгаая. . . . Авралыг өөр ямар ч зарчмаар олж авах боломжгүй.’”

**ТОМАС С.МОНСОН,**  
(Марин Ж.Ромнигоос эш татав), “Guiding Principles of Personal and Family Welfare,” *Ensign*, 1986 оны 9-р сар, 3

### Гадасны бие даах чадвар хөгжүүлэх мэргэжилтэн

Мэргэжилтэн нь бие даах чадвар хөгжүүлэх төвийн бүх үйл ажиллагааг (Гадасны бие даах чадвар хөгжүүлэх хороо, Гадасны бие даах чадвар хөгжүүлэх төв, Бие даах чадвар хөгжүүлэх төвийн менежер) нэгтгэн холбох үүрэгтэй.

1. Гадасны бие даах чадвар хөгжүүлэх хорооны хурлын хөтөлбөрийг бэлтгэх
2. Сүмийн үйлчлэлийн номлогчдод болон сайн дурынханд бие даах чадвар хөгжүүлэх төвийг хэрхэн ажиллуулах талаар зааж сургах
3. Гадасны бие даах чадвар хөгжүүлэх бусад мэргэжилтэнг сургаж, удирдах
4. Шаардлага гарвал бие даах чадвар хөгжүүлэхтэй холбоотой материалыг захиалах
5. Хүсэлтийн дагуу бишопуудыг болон тойргийн зөвлөлийнхнийг сургаж, дэмжих
6. Гишүүдэд [srs.lds.org/register](https://srs.lds.org/register)-г бүртгүүлэхэд нь туслах
7. Бие даах чадвар хөгжүүлэх бүлгүүдийг зохион байгуулж, хянаж, дэмжлэг туслалцаа үзүүлэн, зохицуулах (Шаардлагатай үед бүлгүүдийг зохицуулуулахаар өөр гишүүдийг дуудаж болно.)
8. Онлайнаар [srs.lds.org/facilitator](https://srs.lds.org/facilitator) дээр байгаа зарчмуудыг судалж, дагаж мөрдөх

### Бишопын зөвлөл (эсвэл салбарын ерөнхийлөгчийн зөвлөл)

1. Тойргийн гишүүдэд бие даасан байдлын талаарх сургаал, зарчмуудыг заа (арын хавтсыг үзнэ үү).
2. Тойргийн зөвлөлөөр дамжуулан бие даах чадвар хөгжүүлэх хүчин чармайлтыг удирдан чиглүүл.
  - Бие даах чадвартай болох шаардлагатай бүх гишүүнийг тодорхойлж, тоог гарган, урь. Үүнийг хийхэд [leader.lds.org/self-reliance](https://leader.lds.org/self-reliance) дээрх насанд хүрсэн гишүүдэд зориулсан бие даах чадварын арга хэрэгсэл тустай байж болно.
  - Чуулгын болон туслах бүлгийн удирдагчдаар дамжуулан тусламж хэрэгтэй хүмүүсийг дэмжиж, зөвлөн, туслалцаа үзүүл.
3. Тусламж хэрэгтэй хүмүүсийг *Миний бие даах чадвартай болох арга зам* товхимлыг дуусгаж, бие даах чадвар хөгжүүлэх бүлгүүдэд хамрагдахад урь.
4. Шаардлагатай үед тойргийн бие даах чадвар хөгжүүлэх мэргэжилтэнг бүлгүүдийг зохицуулуулахаар дууд.
5. ТБС-ийн зээлийн батламж олгох ярилцлага хий ([pef.lds.org/loans](https://pef.lds.org/loans)-ийг үзнэ үү).
6. Тойргийн бие даах чадвар хөгжүүлэх үйл ажиллагааны явцын тухай болон ТБС-ийн зээлийн тайлантай танилцан, тэдгээрт үндэслэж үйлд. Бишопууд ТБС-ийн зээлийн төлбөрийг цуглуулах асуудалд оролцох ёсгүй.
7. Шаардлагатай үед гадасны бие даах чадвар хөгжүүлэх хорооноос тусламж дэмжлэг ав.

## ЭХ СУРВАЛЖ

### Бие даах чадвар хөгжүүлэх төвүүд

Гадаснуудыг бие даах чадвар хөгжүүлэх төвийг Сүмийн байранд, гол төлөв гэр бүлийн түүхийн байрыг хамтарч ашиглахаар зохион байгуулахад нь урамшуулан дэмж. Бие даах чадвар хөгжүүлэх төвд Сүмийн үйлчлэлийн номлогчид, сайн дурынхан ажиллах бөгөөд ажил хайгч, хувиараа хөдөлмөр эрхлэгч, оюутан болох гэж буй хүмүүст интернэт ашиглах боломж олгон, заавар зөвлөгөө өгч, хэрэгтэй эх сурвалжаар хангана.



*“Энэ хүмүүсийн хэрэгцээг анхаарч үзэх өөр шинэ байгууллага байгуулах шаардлагагүй. Үүнд зөвхөн Бурханы санваарыг ажиллуулахад л хангалттай.”*

**ХАРОЛД Б.ЛИЙ,**  
*“Admonitions for the Priesthood of God,”*  
*Ensign, 1973 оны 1-р сар, 104*



*“Хэрэв бид Их Эзэний арга замаар, нэг нэгэнтэйгээ зөвлөлдвөл, бүр жинхэнээсээ зөвлөлдвөл гэр бүл, тойрог эсвэл гадасны ямар ч асуудлыг шийдвэрлэх боломжтой.”*

**М.РАССЭЛЛ БАЛЛАРД,**  
*Counseling with Our Councils, засаж сайжруулсан хэвлэл (2012), 4*

## Бие даах чадвар хөгжүүлэх бүлэг

Бие даах чадвар хөгжүүлэх бүлгийн цугларалт нь зөвлөлдөх загварыг ашигладаг бөгөөд Сүмийн ихэнх анги, хичээл, сургалтаас ялгаатай. Энэ бүлэгт багш эсвэл дадлагажуулагч гэж байхгүй. Харин бүлгийн гишүүд хамтдаа зөвлөлдөн, суралцаж, нэг нэгнээ зааж сурган, сурч мэдсэн зүйлсээ хэрэгжүүлэхээр амлалт өгч, түүнийгээ биелүүлэх талаар бие биедээ тусалдаг. Бүлгийн энэхүү зааж сургах, зөвлөлдөх үйл явц нь дасгалын ном, видео бичлэг зэрэгтэй хамт гишүүн бүрийг бие даасан амьдралынхаа төлөө хөгжиж дэвшихэд нь хүчирхэгжүүлэх эрчимтэй суралцах орчинг бий болгоно.

Гадасны болон тойргийн удирдагчид бие даах чадвар хөгжүүлэх бүлгүүдийг зохион байгуулан, зохицуулах бие даах чадвар хөгжүүлэх мэргэжилтнүүдийг дуудна. Бүлгийн зохицуулагчид багш биш бөгөөд харин тэд бүлгийнхэнд гарын авлагад бичигдсэн бие даасан байдлын үйл явцыг дагаж мөрдөхөд тусална. Заримдаа бүлгийн зохицуулагчдад интернэт ашиглах, бүлгийн цугларалтаар видео бичлэг үзүүлэх шаардлага гарна. Удирдагчид шаардлагын дагуу хэчнээн ч бүлгийг зохион байгуулан, хэдэн ч мэргэжилтэнг дуудаж болно. Шаардлагатай үед бүлгийн гишүүдээс зохицуулагчаар ажиллахыг хүсэж болно. Бүлэг тус бүр 8-14 гишүүнтэй байх бөгөөд нэг удаад хоёр цаг үргэлжлэх уулзалт хийхээр 12 удаа цугларна. Бүлгүүд гадасны бие даах чадвар хөгжүүлэх төвд болон Сүмийн байранд эсвэл гишүүдийн хувьд тохиромжтой өөр газарт цугларч болно.

Орон нутгийн удирдагчид дараах бүлгүүдээс аль нь тэдний нэгжид хэрэгтэй болохыг тодорхойлно.

1. *Хувийн бизнесээ эхлүүлж, өргөжүүлэх нь* бүлэг нь хүмүүст хувийн бизнесээ эхлүүлэх эсвэл өргөжүүлэхэд тусална. Эдгээр бүлэг нь хувиараа хөдөлмөр эрхлэх сургалтыг орлодог.
2. *Ажил хайх нь* бүлэг нь хүмүүст шинэ эсвэл илүү сайн ажил олоход тусална. Эдгээр бүлэг нь ажил эрхлэлтийн сургалтыг орлодог.
3. *Илүү сайн ажлын төлөө сурч боловсрох нь* бүлэг нь хүмүүст орлогоо нэмэгдүүлж, сурч боловсрох арга замаа олж тодорхойлоход тусална. Эдгээр бүлэг нь амжилтын төлөө төлөвлөх нь гэсэн сургалтыг орлодог.

Түүнчлэн бүлгийн нэг хэсэг болгон, гишүүд *Миний суурь: зарчим, ур чадвар, дадал хэвшил* товхимол дээрх бие даахтай холбоотой 12 сургаалын сэдвийг судална.

## Сүмийн ажилтанг дэмжих, үр дүнтэй

### эх сурвалжуудын жагсаалт

Сүм нь бие даах чадвар хөгжүүлэх хүчин чармайлтыг дэмжих зорилгоор хөтөлбөрийн бүх хүрээнд хүмүүсийг хамруулж ажиллуулна. Үүнд: бүсийн бие даах чадвар хөгжүүлэх хөтөлбөр хариуцсан менежер, бие даах чадвар хөгжүүлэх хөтөлбөрийн үйл ажиллагаа хариуцсан менежер, бие даах чадвар хөгжүүлэх төвийн менежер болон бусад ажилтан орно. Эдгээр ажилтан гадасны бие даах чадвар хөгжүүлэх төвүүдийн хэрэгцээ шаардлагад уялдуулан эх сурвалжаар ханган, сургалт өгнө. Эдгээр эх сурвалжид зөвлөх, санал болгосон сургууль, хөтөлбөрүүдийн жагсаалт, орон нутаг дахь ажлын байр, бизнес эхлүүлэхэд шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг санхүүжүүлэх санхүүгийн байгууллагын нэрс зэрэг мэдээлэл орно.

## Бие даах чадвар хөгжүүлэх хөтөлбөрийн вэбсайт

Удирдагч, гишүүдэд зориулсан дэлгэрэнгүй мэдээллийг [ref.lds.org-ooc](http://ref.lds.org-ooc) авна уу.

## Би тойргийнхоо эсвэл гадасныхаа гишүүдийн бие даах чадвараа хөгжүүлэхэд гаргаж буй ахицыг хэрхэн хэмжих вэ?

*Та бие даах чадвараа хөгжүүлэхэд нь өөрийн тойрог эсвэл гадсанд туслах үедээ дараах гишүүдийн тоог тогтмол гаргаж, тооцоолох талаар бодож үз:*

1. *Бишопууд бие даах чадваргүй гэж тодорхойлсон.*
2. *Миний бие даах чадвартай болох арга зам товхимлыг үзэж дуусгасан.*
3. *Миний суурь: зарчим, ур чадвар, дадал хэвшил товхимлыг үзэж дуусгасан.*
4. *Бизнес эхлүүлсэн, сайн ажилд орсон эсвэл боловсролын хөтөлбөрт хамрагдсан.*

### Удирдагч, бичиг хэргийн ажилтны мэдээллийн сан (LCR)

Насанд хүрсэн гишүүдэд зориулсан бие даах чадварын хэрэгслүүд нь амьдралын үндсэн хэрэгцээт зүйлсээр дутмаг гишүүдийг тодорхойлон, тэдэнд анхаарлаа хандуулахад бишопуудыг дэмжинэ. Энэ эх сурвалжийг [leader.lds.org/self-reliance](http://leader.lds.org/self-reliance) дээрээс ашиглаж болно.

### Миний бие гаах чадвартай болох арга зам онцгой цугларалт

Гадас, тойргууд *Миний бие даах чадвартай болох арга зам* сэдэвтэй онцгой цугларалтуудыг тогтмол зохион байгуулна. Энэхүү онцгой цугларалт нь гишүүдэд бие даах чадварын талаарх сургаалын ач холбогдлыг ойлгоход туслан, одоогийн бие даасан байдлынх нь түвшинд үнэлгээ хийж, материаллаг тал дээр бие даахад ямар ур чадвар, орлого хэрэгтэй болохыг тодорхойлж, уг зорилгодоо хүрэхэд туслах бүлгийг сонгоход нь тусалснаар бие даасан байдалд хүрэх замыг эхлүүлнэ. *Миний бие даах чадвартай болох арга зам* товхимол нь энэ үйл явцад тусалдаг. Бие даасан байдлын үнэлгээг хувь хүн өөрөө болон санваарын удирдагч, бие даах чадвар хөгжүүлэх мэргэжилтэнтэй хамт, мөн бие даах чадвар хөгжүүлэх төв дээр эсвэл өөр орчинд хийж болно. “*Миний бие даах чадвартай болох арга зам* товхимлыг хэрхэн ашиглах вэ” видео бичлэгийг [srs.lds.org/videos-оос](http://srs.lds.org/videos-оос) үзнэ үү.

### Сургалтын видео бичлэгүүд

Дараах видео бичлэгүүдийг онлайнаар [ref.lds.org/videos-оос](http://ref.lds.org/videos-оос) үзнэ үү.


ҮЗЭХ ХҮМҮҮС	ВИДЕО БИЧЛЭГИЙН ГАРЧИГ	
<b>Удирдагчид</b>	Би Өөрийн гэгээнтнүүдийг хангана	
	Гадасны бие даах чадвар хөгжүүлэх хороо	
	Гадасны бие даах чадвар хөгжүүлэх хорооны хурал	
	Гадасны бие даах чадвар хөгжүүлэх мэргэжилтэн	
	Тойргийн зөвлөлд туслах нь	
	Бие даах чадвар хөгжүүлэх бүлгүүдийг хэрхэн зохион байгуулах вэ	
	Бие даах чадвартай болохын төлөө хөдөлмөрлөх нь	
	<i>Миний суурь: зарчим, ур чадвар, дадал хэвшил</i> видео бичлэгүүд (12)	
	<b>Зохицуулагчид</b>	Миний зорилго
		Бүлгийг хэрхэн зохицуулах вэ?
Хэрхэн бэлтгэх вэ?		
Хэрхэн удирдах вэ: <i>Миний суурь: зарчим, ур чадвар, дадал хэвшил</i>		
Хэрхэн удирдах вэ: Тайлагна		
Хэрхэн удирдах вэ: Судал		
Хэрхэн удирдах вэ: Тунгаан бод		
Хэрхэн удирдах вэ: Амлалт өг		
Хэрхэх вэ: Цугларалтуудыг зохион байгуул		
“Явж, мөн хийх” талаар суралцах нь		

### Санал хүсэлт

Санал, сэтгэгдэл, санаа бодол болон туршлагаа [srsfeedback@ldschurch.org](mailto:srsfeedback@ldschurch.org) эсвэл [srs.lds.org/feedback](http://srs.lds.org/feedback) хаягаар явуулна уу.

## Бүлгийн ашиглах материал

Сургалтын материал, видео бичлэг, сургалтуудыг Gospel Library гар утасны программ болон онлайнаар, [srs.lds.org](http://srs.lds.org) дээрээс харах боломжтой. Түүнчлэн сургалтын материалуудыг Сүмийн хангамжийн төвөөр дамжуулан захиалж болно.



### Миний бие даах чадвартай болох арга зам

Бүх оролцогч энэ номоос эхлэн одоогийн бие даасан байдлынхаа түвшинг тодорхойлж, бие даах чадвартай болоход нь ямар бүлэг туслах талаар шийдвэр гаргана. Хувийн бизнесээ эхлүүлж, өргөжүүлэх ба ажил хайх, сурч боловсрох гэсэн бүлгүүд байгаа.



### Миний суурь: зарчим, ур чадвар, дагал хэвшил

Энэ бүх гурван бүлгийн гишүүд бие даасан байдлын нэн чухал сүнслэг зарчмуудыг ярилцан, хэрэгжүүлэхдээ энэхүү товхимлыг ашиглана.



### Хувийн бизнесээ эхлүүлж, өргөжүүлэх нь

Бизнес эрхэлдэг эсвэл шинээр эхлүүлэхийг хүсэж буй хүмүүст зориулав. Бүлгийн гишүүд баримт бичиг хөтлөлт, зар сурталчилгаа, бэлэн мөнгөний менежментийн талаар дадлага хийнэ. Тэд мөн бизнесийн жижиг туршилтуудаар дамжуулан ашиг орлогоо нэмэгдүүлэх арга замуудыг турших болно.



### Ажил хайх нь

Сайн ажилд тэнцэхүйц ур чадвартай хүмүүст зориулав. Бүлгийн гишүүд ажлын боломжуудыг олж тодорхойлон, танилын сүлжээгээ өргөжүүлж, өөрсдийн давуу талыг танилцуулах, ярилцлагын асуултуудад бэлтгэх зэргээр дадлага хийнэ. Энэ бүлэгт хамрагдсаны үр дүнд ажилтай болно.



### Илүү сайн ажлын төлөө сурч боловсрох нь

Сайн ажилд орохын тулд эсвэл бизнес эхлүүлэхийн тулд боловсрол эзэмших юм уу сургалтад хамрагдах шаардлагатай хүмүүст зориулсан. Бүлгийн гишүүд бие даахад туслах ажлыг тодорхойлон, дараа нь санал болгосон сургууль эсвэл хөтөлбөрийг (үүнд арга зам мөн орно) олж сонгоно. Энэ бүлэгт хамрагдсаны үр дүнд сургуульд орж мөн ТБС-ийн зээлд (хэрэгтэй бол) хамрагдана.

Миний суурь: Зарчим, ур чадвар, дадал хэвшил болон Хувийн бизнесээ эхлүүлж, өргөжүүлэх нь товхимлын шаардлагуудыг хангасан бүлгийн гишүүд ХҮГ Бизнесийн коллежоос гэрчилгээ хүлээн авах боломжтой.

## БИЕ ДААСАН БАЙДЛЫН ТУХАЙ СУРГААЛ, ЗАРЧМУУД

### Сургаалууд

**1. Материаллаг болон сүнслэг зүйлүүд нь нэгдмэл болой**

*Сургаал ба Гэрээ 29:34; Алма 37:38-43*

**2. Их Эзэн бидэнд бие даасан байхыг зарлигласан ба Түүнд бидэнд туслах хүч чадал бий**

*Сургаал ба Гэрээ 104:15-16; 100:1; 1 Нифай 9:6; 2 Нифай 27:21, 23; Мозая 4:9; Матай 28:18*

**3. Бие даасан байдал бол өргөмжлөлийн зарчим болой**

*Сургаал ба Гэрээ 132:20*

### Зарчмууд

Дараах зарчмуудын талаар дэлгэрэнгүй мэдээлэл авахын тулд *Миний суурь*: зарчим, ур чадвар, гадал хэвшил товхимлыг үзнэ үү.

**1. Есүс Христэд итгэх итгэлээ хөгжүүл**

*1 Нифай 9:6; Еврей 11*

**2. Дуулгавартай бай**

*Сургаал ба Гэрээ 93:28; 130:20-21; Абрахам 3:25; Еврей 5:8-9*

**3. Үйлд**

*2 Нифай 2:16, 26*

**4. Үйлчил, мөн нэгдмэл бай**

*Моце 7:18; Галат 5:14*

ЕСҮС ХРИСТИЙН

ХОЖМЫН ҮЕИЙН  
ГЭГЭЭНТНҮҮДИЙН СҮМ

MONGOLIAN

